



ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар A/30

Улаанбаатар хот

Байгууллагын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөл байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь хэсэг, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.2, 6.8.7 дахь заалт 2021 оны Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 01 дугаар тогтоол, 2021 оны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай” A/72 дугаар тушаал тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Залуучуудын хөгжил, оролцоог шийдвэр гаргах түвшинд дэмжих, салбар хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, санал санаачлагыг дэмжих замаар залуучуудын үнэлэмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийг шинээр байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Институтийн дэргэдэх Залуучуудын хөгжлийн зөвлөлийн дүрмийг хэлэлцэн баталж, жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан тухай мэдээ, тайланг байгууллагын даргад болон холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг Залуучуудын хөгжлийн зөвлөл (Э.Уянга)-д үүрэг болгосугай.

3. Зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тайлагнаж ажиллахыг Захиргаа, удирдлага санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүү менежмент хариуцсан орлогч дарга (Б.Батсайхан)-д даалгасугай.

ДАРГА



Ч.ИРЭГЗМАА